

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3 - 4

<i>1. Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал</i>	3 - 4
---	-------

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны 11 дүгээр сарын 29-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Э.Батшугар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 14 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Н.Ганибал, Х.Ганхуяг, Т.Доржханд, Ч.Ундрэм.

Нэг. Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарыг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байгаа талаар танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Э.Батшугар: Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 0
Бүгд: 6
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 04 минут үргэлжилж, 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.6 хувийн ирцтэйгээр 10 цаг 18 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Э.БАТШУГАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
10 цаг 14 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Э.Батшугар: Эрхэм гишүүд энэ өдрийн амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Э.Батшугар 28 дугаар тойрог, Ц.Идэрбат 18 дугаар тойрог, Б.Саранчимэг 22 дугаар тойрог, Ц.Сэргэлэн 7 дугаар тойрог, Н.Учрал 28 дугаар тойрог, Ж.Чинбүрэн 23 дугаар тойрог Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг асуудал байгаа.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орьё.

Байнгын хорооны даргын сонгох тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Байнгын хорооны даргын нэр дэвшигчийг талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монголын Ардын намын бүлгийн гишүүн Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна.

Ц.Идэрбат: Байнгын хорооны эрхэм гишүүдэд энэ өглөөний мэндийг хүргэн дэвшүүлье.

Өнөөдөр Монгол Улсын Их Хурлын бүтцийн байгууллага болох Байнгын хорооны даргын асуудлууд яригдаж байна.

Өнөөдрийн хувьд Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргын асуудал та бид хэлэлцэх гэж байна. энэ хурлын өмнө Монголын Ардын намын бүлгийн Инновац, цахим бодлогын байнгын хороонд харьяалагддаг гишүүдийн хурал болж, уг хуралд Монголын Ардын намын бүлгийн дэд дарга Э.Бат-Амгалан оролцож Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн.

Монголын Ардын намын гишүүдийн хувьд Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар сонгогдон ажиллаж байгаа Энхбаярын Батшугар гишүүнийг цаашид үргэлжлүүлж ажиллахыг дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт болсон гэдийг Байнгын хорооны гишүүдэд танилцуулж байна. Баярлалаа.

Э.Батшугар: Ц.Идэрбат гишүүндээ баярлалаа.

Нэр дэвшигчээс асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Танилцуулгатай холбоотой үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалт явуулъя.

Өөр нэр дэвшүүлэх хүн байна уу? Байнгын хорооны даргад. Алга байна.

Санал хураалт явуулъя. Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар Энхбаяр овогтой Батшугарыг нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны даргыг сонгох асуудлыг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Улсын Их Хурлын чуулганд Байнгын хорооны дүгнэлтийг Б.Саранчимэг гишүүнд танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

Хүрэлцэн ирсэн гишүүддээ баярлалаа.

Хуралдаан 04 минут үргэлжилж, 10 цаг 18 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД